



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 30

Арвайхээр

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Амар тайван Өвөрхангай” хөтөлбөрийг нэгдүгээр, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган, хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /А.Ишдорж/-д даалгасугай.


3. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

О. ПҮРЭВДОРЖ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр сарын 26-ны  
өдрийн 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



## “АМАР ТАЙВАН ӨВӨРХАНГАЙ” ХӨТӨЛБӨР

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Иргэдийн Үндсэн хуулиар хамгаалагдсан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, төр, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хүртээмжийг нэмэгдүүлэх, тодорхой төрлийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр энэхүү хөтөлбөрийг орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулав.

1.2. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн сүүлийн 5 жилийн судалгааг хийж, шалтгаан нөхцөл, нөлөөлөх хүчин зүйлс, түүнтэй тэмцэх туршлага, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны өнөөгийн байдалд криминологи, математик статистикийн шинжлэх ухааны үүднээс үнэлэлт, дүгнэлт хийж, цаашид орон нутгийн хэмжээнд тодорхой цаг хугацаанд гэмт хэргийн мөн чанарт гарсан тооны ба чанарын өөрчлөлт, гэмт хэргийн хөдөлгөөний үзүүлэлт нь гэмт хэргийн үнэмлэхүй өсөлт, бууралт өсөлтийн хурдац (бууралт) хэмжээ буюу түвшнийг илэрхийлж байгаа статистик мэдээлэл, бусад тайлан мэдээлэлд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийн зорилт арга хэмжээг тодорхойлов. Мөн түүнчлэн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллага, гэр бүл, иргэдийн оролцоо чухал үүрэгтэй тул гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг тэдгээрийн оролцоонд түшиглэн тасралтгүй хэрэгжүүлэх нь үр дүнтэй байна.

1.3. Энэхүү хөтөлбөр нь аймгийн хэмжээнд ихэвчлэн үйлдэгдэж буй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг, хүрээлэн буй орчны эсрэг, архи дан согтуурахтай тэмцэх гэмт хэргүүдийг бууруулах, иргэдийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

### ХОЁР. ХӨТӨЛБӨР ЗОРИЛГО, ЗОРИЛТ

#### 2.1. Зорилго

Иргэдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн дэг журмыг сахиулах, иргэд, олон нийтийн хууль, эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, хууль зүйн туслалцааны хүртээмжийг



5.2. Гэмт хэргийн улмаас иргэдийн амь нас эрсдэх, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирлын хэмжээ буурсан байна.

5.3. Улсын чанартай замын хяналт шалгалт тогтмолжиж иргэд амь насаа алдах эрсдэл буурч, аюулгүй байдал сайжирна.

5.4. Шинээр батлагдсан хуулийн хэрэгжилт хангагдаж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа дээшилнэ.

5.5. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлаараа улсын хэмжээнд жишиг аймаг болно.

### **ЗУРГАА. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ**

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээсэн сум, байгууллагуудын удирдах албан тушаалтан бүр санаачлан хэрэгжүүлсэн, хүрсэн үр дүнг хагас, бүтэн жилээр сүүлийн сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст илрүүлнэ.

6.2. Хууль, эрх зүйн хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дүгнэлт хийж, аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулна.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад идэвхи санаачлагатай ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн сайн дурын нөхөрлөл, хоршоо, малчдын бүлэг нөхөрлөл, иргэнийг тус тус шалгаруулан хөтөлбөрийн санхүүжилтээс шагнаж урамшуулна.

6.4. Сум, байгууллагуудын жилийн үйл ажиллагааг дүгнэх шалгуур үзүүлэлтэд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг оруулж тооцох бөгөөд жил бүр идэвхи санаачлагатай ажилласан сум, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, иргэдийн сайн дурын нөхөрлөл, хоршоо, бүлэг, холбооны иргэдийг урамшуулна.

зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлж, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэхэд мөн хөтөлбөрийн зорилго оршино.

## 2.2. Зорилт

2.2.1. Иргэдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлж, олон нийтэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээрх үйл ажиллагааг өргөжүүлэн, эрх зүйн хөтөч ажиллуулах, хууль зүйн туслалцааны төв дэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.2. Хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэний нийгэм-хувийн хэвшил-төрийн түншлэлийг бэхжүүлнэ.

2.2.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалахад аймаг, сумын төвийн орон сууц, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, гэрлэн дохиог нэмэгдүүлж, теле-камерын хяналтын системийг хөгжүүлнэ.

2.2.4. Зохион байгуулалттайгаар үйлдэгдэх мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, хүүхэд хамгаалал, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлнэ.

2.2.5. Нийгэмд түгээмэл буй архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэл, өмчлөх эрхийн эсрэг зөрчил, зам тээврийн осол зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бууруулах, таслан зогсоох, хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих, урьдчилан сэргийлэх, дээрх гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, эсхүл үйлдэгдэж болзошгүй газар нутаг, үйл ажиллагаа, харилцаанд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.6. Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг сурталчилж, хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлж, цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг сайжруулан, төрийн албан хаагч, иргэдийн технологийн мэдлэг, инновацыг ашиглах чадавхыг дээшлүүлнэ.

2.2.7. Хөдөө аж ахуй, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, сайн дурын бүлэг, нөхөрлөлийг чадавхжуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, гэмт хэргийн гаралтыг бууруулна.

## ГУРАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО

3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, хууль сахиулах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн байгууллагууд манлайлан зохион байгуулна.



3.2. Харьяа нутаг дэвсгэр, байгууллагын хэмжээнд хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллах чиг үүргийг нутгийн захиргааны байгууллага, холбогдох хууль, хяналтын байгууллагууд хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь тайланг нэгтгэн, хагас жил тутам хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан, Засаг даргын зөвлөлд танилцуулна.

### 3.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга

3.3.1. Хөтөлбөрийн зорилт үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлог тулгамдсан асуудалд тулгуурласан төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудад заасан үүргийн биелэлтийг хангуулах;

3.3.3. Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах нэвтрүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тогтмолжуулах, урьдчилан сэргийлэх олон нийтийн байгууллага, хамт олныг дэмжин урамшуулах;

3.3.4. Сум, багийн Засаг дарга төрийн байгууллагуудын үйл ажиллагааг дүгнэхдээ гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг нэг үзүүлэлт болгон ажилласан байгууллага, хамт олныг дэмжин урамшуулах;

### 3.4. Хууль, хяналтын байгууллагууд

3.4.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд тухайн орон нутагт гарсан гэмт хэрэг зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.4.2. Хуулийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах хүрээнд тогтмол уулзалт, хамтарсан арга хэмжээг зохион байгуулах;

3.4.3. Зам тээврийн осол хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт сурталчилгааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд зохион байгуулан ажиллах;

3.4.4. Гэмт хэрэг, зөрчлийн дуудлагад цаг алдалгүй очиж иргэдэд түргэн шуурхай үйлчилж, иргэдийн аюулгүй амар тайван орчинд амьдрах эрхийг хангах ажлыг зохион байгуулж явуулах;

3.4.5. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг гүйцэтгэхэд иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;

3.4.6. Хөтөлбөрийн зорилтод хүрэх үйл ажиллагааны чиглэлүүдийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангах, иргэдэд тайлагнах, сурталчлах;

3.4.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлэг тогтмол хүргэх;

3.4.8. Төв суурин газрын цэвэр усны хамгаалалт болон онцгой, объектуудын аюулгүй байдал, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, цацраг идэвхт болон химийн хорт бодисын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд шалгалтыг жил бүр хийх;

3.4.9. Түүх, соёлын дурсгалт зүйлсийн хамгаалалтыг сайжруулах, хууль бус ан, ургамал, ашигт малтмалыг улсын хилээр нэвтрүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;

### 3.5. Бусад аж ахуйн нэгж, байгууллагууд

3.5.1. Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага, зөв зан үйлийг эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгааг нийтлэх, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө тусгах цагийг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой санал санаачлага гарган, хамтарч ажиллах;

3.5.2. Төрийн бус байгууллага нь хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхэд өөрсдийн зүгээс идэвхитэй оролцох, бусад байгууллагатай хамтран үр ашигтай ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх;

3.5.3. Аж ахуй, нэгж байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд идэвхитэй оролцох үүргийг хүлээх;

### 3.6. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

3.6.1. Хөтөлбөрийг 2021-2024 оныг дуустал хэрэгжүүлнэ.

### 3.7. Хөтөлбөрийн санхүүжилт

3.7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээс бүрдэнэ.

3.7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил бүрийн аймгийн ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны болон аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, бусад хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус тус тусгаж хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

### 4.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ



4.1.1. Сум бүрт эрх зүйн танхим байгуулан, иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх, мэдлэг олгох, бусад шаардлагатай хууль зүйн туслалцааны үйлчилгээг нэмэгдүүлж, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн актуудыг иргэдэд ойлгомжтой байдлаар хууль, тогтоомжийн лавлагаа, мэдээллийн санг баяжуулж, хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

4.1.2. Сум бүрт сайн дурын эрх зүйн хөтөчийн ажиллах журмын дагуу эрх зүйн хөтөч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд иргэдийн мэдвэл зохих хууль тогтоомжийн мэдлэг олгох, онол арга зүйн зөвлөгөө өгөх болон иргэдэд хууль эрх зүй сурталчилах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, эрх зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулж, чадавхижуулна.

4.1.3. Эрх зүйн мэдээллийг олон нийтэд хүргэхдээ интернет, телевиз, цаасан хэвлэл, танхимын сургалт, хэлэлцүүлэг зэрэг мэдээллийн олон сувгийг ашиглах, ялангуяа хөдөөгийн алслагдсан иргэд, зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан сургалт, сурталчилгааны шинэ арга барилыг түгээх, эрх зүйн мэдээллийг хүртээмжтэйгээр олж авах, шинээр батлагдсан хууль тогтоомжийг шуурхай, ойлгомжтойгоор хүлээн авах, хууль төрөхийн өмнө хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож саналаа хэлэх замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийг амьдралд хэрэгжихэд бодитойгоор хувь нэмрээ оруулах боломж бүрдүүлнэ.

#### **4.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.2.1. Хууль сахиулах болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг нэмэгдүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулж, үр дүнг олон нийтэд мэдээлж ажиллана.

4.2.2. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар тогтмол хяналт тавьж, хүний эрхийн асуудлаар төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллана.

4.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдол, мэдээллийг шуурхай шийдвэрлэх, хууль, хяналтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, гэрч хохирогчийг хамгаалах орчныг бэхжүүлэх, хүний эрхийн зөрчлийн асуудлаар судалгаа хийж, орон нутгийн онцлогт тохирсон цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

#### **4.3. Гуравдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.3.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах ажилд хөршийн холбоо, гудамжны ахлагчийг ажиллуулах гэх мэт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, аймаг, сумын төвийн орон сууц, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг, гэрлэн дохиог нэмэгдүүлж, теле-камерын хяналтыг тасралтгүй сайжруулна.



4.3.2. Харьяа нутаг дэвсгэрийн томоохон голын гүүр, улсын чанартай авто замын дагуу байрлах шатахуун түгээх станц, үйлчилгээний цэг, тээврийн хэрэгслийн зогсоолын цэгүүдэд теле-камер байрлуулах, тээврийн хэрэгслийн улсын дугаар танигч "LPR" камерыг суурилуулах ажлыг улсын болон орон нутгийн төсөв, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор үе шаттайгаар шийдвэрлэнэ.

4.3.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн төв дэх хяналтын камерын нэгдсэн хяналтын үйл ажиллагааг өргөжүүлж, мэдээлэл, харилцаа холбоо, барилга байгууламжийн дэд бүтцийг орчин үеийн камерын стандартын шаардлагад нийцүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.3.4. Сургууль, цэцэрлэгийн орчныг бүрэн камержуулах ажлыг боловсролын байгууллагатай хамтран хэрэгжүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулах, үе тэнгийн дарамт, дээрлэхлэлтийг таслан зогсоох, сургууль орчны аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

#### 4.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.4.1. Хүн амын бүлгийн талаарх мэдээллийг агуулсан томоохон мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэнтэй холбогдуулан нутаг дэвсгэрийн эрсдэлтэй хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, хүн амын дундах хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон улсад шинэ тутамд гарч байгаа гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлнэ.

4.4.2. Хүүхэд хамгааллын бодлогын тулгамдсан асуудал хүүхэд гуйлга гуйх, хулгай хийх болон хурдан морь унах, мал маллах, эсвэл хогийн цэг дээр хог түүх, барилга зэрэг эдийн засгийн албан бус салбарт албадан хөдөлмөр эрхэлж болзошгүйд байнгын хяналтыг нэмэгдүүлж, зарим тохиолдолд гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлж бэлгийн мөлжлөгт оруулж болзошгүй тул таслан зогсоох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

4.4.3. Хүн худалдаалах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалт сурталчилгаа үр дүнтэй зохион байгуулж, энэ төрлийн зар сурталчилгаанд тавих хяналтыг сайжруулна.

4.4.4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэгт хяналт тавих чиглэлээр тусгайлсан чиг үүрэг хүлээсэн байгууллагуудын албан хаагчдыг чадавхижуулах, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

#### 4.5. Тавдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.5.1. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил, олон нийтийн байгууллага, сайн дурын иргэдийн нэгдэл "АА" бүлгийг идэвхижүүлэх, тэдний санал санаачлагыг дэмжин ажиллаж, архидан согтуурахтай тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах, архины хамаарлын эсрэг олон талт арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.



4.5.2. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурсан этгээдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах, донтох өвчний хор уршигтай тэмцэх үйл ажиллагааг тогтмолжуулж, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлүүлэх, эмчлэгдсэний дараах нөхөн сэргээх үйлчилгээ, ажлын байраар хангах гэх мэт арга хэмжээг зохион байгуулна.

4.5.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, таслан зогсоход үүрэг хүлээж, төрийн бүх шатанд ажиллаж байгаа албан хаагчдыг чадавхижуулах, орон нутгийн түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, тэнд ажиллах албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан гэх мэт зорилтот бүлгүүдэд чиглэсэн олон талт арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлнэ.

4.5.4. Зам тээврийн осол болон ахуйн осол нь урьдчилан сэргийлэх боломжтой, осол гарахад нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйл нь тодорхой асуудал тул нутаг дэвсгэрийн онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж, тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөнд оролцогчдод чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг шинэ технологи, арга зүйд тулгуурлан хэрэгжүүлнэ.

4.5.5. Хүүхдийг осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сургууль орчмын бүс”-ийг тодруулах, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хууль тогтоомжийн сургалт, хяналт шалгалтын үйл ажиллагааг тогтмолжуулна.

#### 4.6. Зургаадугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.6.1. Орчин үеийн техник, технологийн дэвшил хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ нийгмийн бусад сөрөг үзэгдлүүдийн нэг болох “цахим” гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаад анхаарч иргэдийн эд хөрөнгө, алдар нэр, хувийн нууц, аюулгүй байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд хууль бусаар халдаж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, гэмт хэргийн нийгмийн хор уршгийн талаарх ойлголт хандлагыг төлөвшүүлнэ.

4.6.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд цахим мэдээллийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдтэй тэдгээрийн хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээхдээ бусдын эрх чөлөөг хамгаалах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандахад хуулийн хүрээнд ажиллах талаар уриалга, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж ажиллах, олон талт санал санаачлагыг дэмжин хамтран ажиллана.

4.6.3. Хүүхэд, өсвөр үеийнхнийг дэлгэцийн донтолт, цахим орчны гэмт хэрэг, хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн техник, технологийн зохистой хэрэглээг дэмжихэд эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр жил бүр соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.

4.6.4. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн мэдээллийг солилцох, хүүхэд залуучуудыг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа хууль, хяналтын байгууллагын албан хаагчдыг чадавхижуулна.



#### 4.7. Долдугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.7.1. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт, шалтгаан нөхцөл түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, харьяа нутаг дэвсгэр дэх хамгаалалтын бүс орчмын мод огтлох, усыг бохирдуулах, хууль бусаар ашиг малтмал, элс, хайрга олборлох, байгаль орчныг бохирдуулах үйлдлүүдэд хяналт тавьж, энэ талаар олон нийтийн хэвлэл мэдээллээр мэдээлэгдэж байгаад анхаарлаа хандуулж, цогц арга хэмжээ авч ажиллана.

4.7.2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр тогтоосон хориглолт, хязгаарлалтын бүсэд хамрагдах талбайд барилгын хог хаягдал хаях, аялал жуулчлалын улиралд голын эрэг дагуу төв замаас салаалсан олон шороон замаар хүмүүс зорчиж голын эрэг дээр гал түлэх, хог хаягдал хаях, машин угаах, зөвшөөрөлгүй худалдаа наймаа эрхлэх зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулдаг нь голын гольдирол, байгалийн нөөцөд сөргөөр нөлөөлдөг тул голын дагуух тодорхой цэгүүдэд сурталчилгааны самбаруудыг байршуулах, камержуулах, холбогдох мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хяналт шалгалт, цэвэрлэгээ хийх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг явуулах, сургалт явуулах зэрэг төрөл бүрийн арга хэмжээг тогтмолжуулна.

4.7.3. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт шинжилгээ хийх, хохирлыг тооцох нь нэлээд цаг хугацаа шаардсан, зардал ихтэй байдаг тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг цаг алдалгүй гаргадаг байх, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулж, экологид учруулсан хохирлыг буруутай иргэн, хуулийн этгээд заавал барагдуулах ажлыг эрчимжүүлнэ.

4.7.4. “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсэг” байгуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх, сум, багт малчдын бүлэг нөхөрлөл байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх, иргэд, олон нийтийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулна.

4.7.5. Иргэд малыг хариулга маллагаатай байлгах, туслах малчин авч ажиллуулахдаа хүнээ зөв сонгох, адуунд “GPS” суурилуулж, тамга тэмдэгтэй болгох, малаа зурагжуулж гэх мэт эрэл хайлт хийх ажлыг хөнгөвчлөх санал санаачлага бүхий нөлөөллийн үйл ажиллагааг бүх шатанд эрчимжүүлж, малын хулгайтай тэмцэх хуулийн тогтоомжийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулна.


4.7.6. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, хууль бусаар булш хиргисүүр ухаж сүйтгэх, тонож дээрэмдэх, эвдэж гэмтээх, өөр зүйлд ашиглах, анхны байрнаас нь зөөх явдал гарч байгааг таслан зогсоож, хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

#### ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

5.1. Гэмт хэрэг, зөрчил, зам тээврийн ослын тоо буурч, осол гэмтэлд өртсөн этгээдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 24 дүгээр сарын 26-ны  
өдрийн 30 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



### АМАРТАЙВАН-ӨВӨРХАНГАЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (тоо, хувиар)			
			2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1.	Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэн, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх.	Бэлтгэгдэн ажиллаж буй эрх зүйн хөтчийн тоогоор	45	60	70	80	90
		Шинээр байгуулсан эрх зүйн хөтчийн булангийн тоогоор	1	4	8	12	16
2.	Хууль зүйн туслалцааны төв дэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.	Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн иргэдийн тоогоор	76	100	130	150	180
3.	Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, гомдол мэдээллийг бууруулах.	Гомдол, мэдээллийн тоогоор	15	10	8	6	4
4.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийтийн хэв журмыг хамгаалах зорилгоор хяналтын камерын нэмэгдүүлэх.	Шинээр нэмэгдсэн хяналтын камерын тоогоор	138	145	150	155	160
5.	Гэр бүлийн хүчирхийлэлээс үүдэлтэй гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн бууралтын хувиар	4	40%	50%	60%	70%
6.	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн бууралтын хувиар	193	20%	30%	40%	50%



7.	Зам тээврийн ослоос үүдэлтэй гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн бууралтын хувиар	20	10%	20%	30%	40%
8.	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн бууралтын хувиар	45	20%	30%	40%	50%
9.	Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн бууралтын хувиар	50	10%	20%	30%	40%

\_\_\_oOo\_\_\_